



national life

**Жилийн тайлан
2023**

Lead by Gund

АГУУЛГА

1. БИДНИЙ ТУХАЙ

Компанийн туйлын зорилго, хэтийн зорилго, үнэт зүйлс

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

Түүхэн замнал

2. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2023 оны онцлох үйл явдал

Даатгалын үйл ажиллагаа

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа

Нийгмийн хариуцлага

3. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ТУЗ гишүүд

Хувьцаа эзэмшигчдийн хурал

ТУЗ-ийн хурал

Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт

Сонирхлын зөрчилтэй хэлцлийн тайлан

Гүйцэтгэх захирлын үүрэг, цалин урамшуулал олгох шалгуур

Дотоод аудит тогтолцоо

4. САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Санхүүгийн үзүүлэлт

Аудитлагдсан тайлан

Зарчим

НЭГДМЭЛ ЗОРИЛГОДОО ЗАХИРАГД

ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЖ ҮР ШИМЭЭ ХҮРТ

ИЛ ТОД БАЙ

БАРИМТ, НОТЛОГООНД ҮНДЭСЛЭ

ТАСРАЛТГҮЙ САЙЖИР



АМЬДРАЛЫН ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГААР ӨРХ БҮРИЙН ЗОРИЛГОДОО ХҮРЭХ САНХҮҮГИЙН БАТАЛГААГ БИЙ БОЛГОЖ НИЙГЭМД ХҮРТЭЭМЖТЭЙ ҮНЭ ЦЭНИЙГ БҮТЭЭНЭ.

Амьдралын даатгалын үйл ажиллагаагаар өрх бүрийн зорилгодоо хүрэх санхүүгийн баталгааг бий болгох

Хүн бүрийн хэрэгцээнд тохируулан угсардаг хэв шинж бүхий хуримтлал, хөрөнгө оруулалтын удирдлага болон эрсдэлийн хамгаалалттай бүтээгдэхүүнийг төгөлдөржүүлж, дижиталжуулах замаар зах зээлд үйлчилгээг үзүүлнэ

Системийн үйл ажиллагааны үр дүнгийн тогтвортой өсөлтийг бий болгодог стратегийн болон төрөлжсөн тогтолцоонуудыг төгөлдөржүүлнэ

Нийгэмд хүртээмжтэй үнэ цэнийг бүтээнэ.

Жил бүр 10 тэрбум төгрөгөөс доошгүй нөөц санг шинээр байгуулдаг байх

ТУС БОНД индексийн төлөвлөсөн түвшинг тогтвортой хангадаг байх

Компанийн хувьцаа Монголын хөрөнгийн биржийн ТОП 20 индекст тогтмол багтдаг байх

СҮДҮ төлөвлөсөн түвшинг тогтвортой хангадаг байх

Хөдөлмөрийн нөөцийн тогтворжилтын индексийн зорилтот түвшинг тогтвортой хангадаг байх

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

“Нэйшнл лайф даатгал” ХХК нь амьдралын даатгал буюу урт хугацааны даатгалын анхны компани бөгөөд 2007 оноос эхлэн мэргэшин 17 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна. Манай компани байгуулагдсан цагаасаа эхлэн зах зээлд амь насны даатгал, хувийн эрүүл мэндийн даатгал, хуримтлалын даатгал, тэтгэврийн даатгалын чиглэлээр, мөн хүнд өвчний эрсдэлийн даатгал буюу хорт хавдрын, зүрх судасны өвчний даатгалуудыг нэвтрүүлэн ажиллаж ирсэн. Үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн өөрсдийн үзүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээг таниулах үйл ажиллагаагаараа дамжуулан даатгуулах соёлыг амжилттай түгээж байгаа гэж бид хардаг.

Бид 2023 онд хэрэглэгчдийнхээ мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг хангахад анхаарлаа хандуулж ажиллаа. Үүнд хүрэхийн тулд бид ISO 27001 шийдлийг хэрэгжүүлэх, мэдээллийн аюулгүй байдлын төрөлжсөн тогтолцооны суурь шийдлүүдийг нэвтрүүлэх ажлыг бэлэн болгоод байна. Хэрэглэгчдийн мэдээллийн аюулгүй байдал, нууцлалын хамгаалалтыг чангаруулах тал дээр зорин ажиллаа. Түүнчлэн хүний нөөц, удирдлагын боловсон хүчний ур чадварыг дээшлүүлэх зорилготой “Мэдлэг түгээе”, “Өрхийн санхүүгээ удирдах нь” зэрэг үнэ төлбөргүй сургалтуудыг амжилттай зохион байгуулсан билээ.

Мөн 2023 онд эрүүл мэндийн даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх, сайжруулах ажлын хүрээнд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хамгийн их өвчилдөг өвчнүүдийг хамгаалалтад авсан “Ээжийн даатгал”, “Аавын даатгал”-ыг зах зээлд нэвтрүүлэн ажиллаж байна. Нэмж дурдахад бид олон улсын эрүүл мэндийн даатгалд хамрагдсан даатгуулагчид БНСУ-д элэг шилжүүлэн суулгах мэс заслыг амжилттай зохион байгуулж эмнэлгийн тусламж, үйлчилгээнд нөхөн олговор олгож хүнд хэцүү цаг үед даатгуулагчдадаа санхүүгийн чухал дэмжлэг үзүүлж чадсандаа таатай байна. Түүнчлэн хэрэглэгчидтэйгээ илүү ойртохыг зорин хотын А зэрэглэлд оффисын бэлтгэл ажлыг эхлүүлээд байна.

Цаашид бид үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулан эрхэм харилцагч, түнш, хувьцаа эзэмшигчид хамтрагчдынхаа хэрэгцээ шаардлага, хүсэл сонирхолд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэн ажиллахаа илэрхийлж байна. Бидэнд итгэн хамтран ажилладаг хамтрагч байгууллагууд болон нийт харилцагч нартаа талархал илэрхийлье!

Сэтгэл тайван амьдралыг хамтдаа бүтээе!

Хүндэтгэсэн,

Нэйшнл лайф даатгал ХХК-ийн Гүйцэтгэх захирал

Г.Монголхүү



Түүхэн замнал

Энэтхэг улсын J.B Boda&Co.Pvt даатгалын зөвлөх компанитай хамтран ажиллах амьдралын даатгалын үйл ажиллагааг эхлүүлэх суурийг тавив.



2007 он

Олон улсын эмнэлгийн болон аяллын түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэгч "International SOS" компанитай хамтран ажиллах гэрээ байгуулав.



2008 он

Германы Munich Re компанитай хамтран ажиллаж, компанийн найдвартай ажиллагааг баталгаажуулав.



2008 он

Монголд анх удаа урт хугацааны эрүүл мэндийн даатгалыг нэвтрүүлэв.



2009 он

2007 он



Монголын анхны амьдралын даатгалын компани болж байгуулагдав

2008 он



Урт хугацааны даатгалын үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл авч даатгалын салбарт нэгэн шинэ хуудас нээлээ

2008 он




Амьдралын даатгалын үндсэн төрөл болох хугацаат амьдралын даатгал болон хуримтлалын даатгалыг зах зээлд нэвтрүүлээ.

Өөрийн оффисыг шинээр барьж ашиглалтад оруулав.



2011 он

Тэнүүн амьдрал тэтгэврийн даатгалыг Төрийн банктэй хамтран борлуулж эхлэв.



2014 он

Олон улсын эрүүл мэндийн даатгалтай даатгуулагчийн элэг шилжүүлэн суулгах мэс заслыг Солонгос улсад амжилттай зохион байгуулж 450 сая төгрөгийн нөхөн төлбөр олголоо.



2020 он

Ажилчдадаа компанийнхаа хувьцаа эзэмшүүлж эхлэв.



2022 он

Дотоодын эрүүл мэндийн даатгалын зах зээлд Аав, Ээжийн даатгал болон Энхжин эрүүл мэндийн даатгалыг нэвтрүүлээ.

2010 он



Бодит санд тулгуурласан хувийн тэтгэврийн даатгалын үйлчилгээг даатгалын салбарт анх удаа нэвтрүүлэв.

2013 он



Байгууллага хамт олонд зориулсан хүнд өвчин мэс заслын хамгаалалт бүхий "Энэр" эрүүл мэндийн даатгалыг зах зээлд танилцууллаа.

2017 он



Монголын хамгийн анхны хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүн Энх-Амьдрал Хорт хавдрын даатгалыг зах зээлд нэвтрүүлээ.

2021 он



Олон улсын чанарын тогтолцоо ISO 9001:2015 нэвтрүүлж SFC X X K - р баталгаажуулав. "Ковид-19" даатгалын хохиролд 1 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгов.

2023 он



Олон улсын эрүүл мэндийн даатгалтай даатгуулагчийн элэг шилжүүлэн суулгах мэс заслыг Солонгос улсад амжилттай зохион байгуулж 240 сая төгрөгийн нөхөн төлбөр олголоо.

2023 онцлох үйл явдал



"Олон улсын эрүүл мэндийн даатгал"-д хамрагдсан даатгуулагч хүнд хэлбэрийн элэгний хатууралтай болсноор элэг шилжүүлэн суулгах мэс засал хийлгэх шаардлагатай болсон. Компанийн зүгээс тус даатгуулагчийг БНСУ-ын тэргүүлэх эмнэлэгт эмчлүүлж, эмчилгээний зардлыг шууд тооцоо хийж барагдуулах замаар шаардлагатай эмнэлгийн тусламж үйлчилгээгээр шуурхай хангаж ажиллаа.



Хүний нөөц, удирдах ажилтнуудад зориулсан "Мэдлэг түгээе" болон "Өрхийн санхүүгээ удирдах нь" үнэ төлбөргүй сургалтыг амжилттай зохион байгуулсан. Сургалтаар дамжуулан бид байгууллагын ажилтнуудад ажил үүргээ биелүүлэхэд шаардлагатай арга хэрэгсэл, ойлголтоор хангахыг хичээж ажиллаа.



Монгол эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд тулгамдаж буй хүнд өвчлөлийг хамгаалалтад авсан Ээжийн даатгалыг боловсруулан зах зээлд нэвтрүүлсэн. Уг даатгалын хүртээмжтэй байдлыг эрхэмлэн хэрэглэгчид санхүүгийн дарамт учруулахгүйгээр хамгийн боломжтой хураамжийг санал болгож байна.

Мөн хөрөнгө оруулалтын багц болон амь насны даатгал хосолсон бүтээгдэхүүн болох "Зорилготой хуримтлалын даатгал"-ыг зах зээлд амжилттай нэвтрүүлсэн. Харилцагч өөрийн хуримтлалаа мэргэжлийн санхүүгийн байгууллагаар удирдуулан хөрөнгө оруулалтын өгөөжийг шууд хүртэх боломжийг олгож байна.

Даатгалын үйлчилгээ

Нэйшнл лайф даатгал нь 2007 онд үүсгэн байгуулагдсан амьдралын даатгалын компани бөгөөд үндсэн 4 төрлийн нийт 15 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчдадаа санал болгож байна. Бид даатгуулагчид болон тэдний хайртай хүмүүсийн санхүүгийн ирээдүйг хамгаалах мөн зорилтот хэрэглэгчдийн хэв шинж, хэрэгцээнд тааруулсан үйлчилгээг хүргэхийг зорин ажиллаж байна.

Бид эрүүл мэндийн үйлчилгээний зардлыг шийдвэрлэх, чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх эрүүл мэндийн даатгалын олон төрлийн шийдлүүдийг санал болгож байна. Түүнчлэн тэтгэвэрт гарах төлөвлөлтийн цогц үйлчилгээг хэрэглэгчдэдээ хүргэж байгаа нь тэтгэвэрт гарахдаа санхүүгийн хувьд санаа зовохгүй байх боломжийг олгож байна.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ

Итгэл дүүрэн амьдрал эрүүл байхаас эхлэлтэй.

Lead by Gund



АМЬ НАСНЫ ДААТГАЛ

Таны амлалтыг биелүүлнэ.

Lead by Gund



ЗОРИЛГОТОЙ ХУРИМТЛАЛЫН ДААТГАЛ

Зорилгодоо хүрэх алхам бүрийн хөтөч.

Lead by Gund



ТЭТГЭВРИЙН ХУРИМТЛАЛЫН ДААТГАЛ

Сэтгэл тайван амьдралыг мэдрүүлнэ.

Lead by Gund

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг хийх нь үйлчлүүлэгчид бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар ямар сэтгэгдэлтэй байгааг тодорхойлох хамгийн үр дүнтэй арга юм. Бид ISO 9001:2015 дэлхийн стандартын дагуу хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг тогтмол хийдэг. Энэхүү стандартын зорилго нь алдаа, согогийг бууруулах,арилгах,хамгийн чухал нь урьдчилан сэргийлэхэд оршино. I S O 9 0 0 1 Чанарын удирдлагын тогтолцоонд үйлчлүүлэгч үргэлж эхний байранд байдаг ба үүнээс гадна хэрэглэгчийн сэтгэл ханамжийг хянах зорилгоор хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг тогтмол хийх хэрэгтэй байдаг.


2023 онд хийгдсэн судалгаагаар ажилчдын харилцаа эелдэг, найрсаг байдлын талаар дийлэнх хэрэглэгчдийн санал эерэг гарсан. Харин 3,4,5 -р саруудад нөхөн төлбөрийн ачаалал нэмэгдэж , улмаар хянан шийдвэрлэх хугацаа удааширсантай холбоотой хэрэглэгчдийн гомдол санал нэмэгдэж сэтгэл ханамжийн түвшин буурчээ.

Уг асуудлыг шийдвэрлэхийн тулд бид 1 нөхөн төлбөрийн эмчид оногдох ачааллыг бууруулах зорилгоор мөн нөхөн төлбөр шийдвэрлэлтийг түргэсгэхийн тулд нөхөн төлбөрийн эмчийг 3 дахин нэмэгдүүлсэн.


Мөн нөхөн төлбөрийн шууд төлбөр тооцооны кредит карттай холбоотой зарим асуудал хэрэглэгчдэд хүндрэлтэй байсан тул Mylife.mn сайтаар дамжуулан өөрийн картын мэдээллийг хялбар хянах боломжийг бий болгож асуудлыг шийдвэрлэж ажиллаа.

Бид сар бүр хэрэглэгчдээсээ сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч цаашдын үйл ажиллагаагаа сайжруулахыг зорьж ажиллаж байна.

1.Нэйшнл лайф даатгалаар үйлчлүүлсэн хэрэглэгчдийн сэтгэл ханамжтай байдал



2.Ажилтаны харилцаа эелдэг, найрсаг байдал



Нийгмийн хариуцлага

Бид урт хугацааны болон богино хугацааны стратегийн зорилтын хүрээнд байгаль орчин, хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд учирч буй эрсдэл, сөрөг нөлөөллийг бууруулахад шаардлагатай арга хэмжээнүүдийг үр дүнтэй, тогтвортой хэрэгжүүлэхийг зорин ажиллаж байна.

Энэхүү хүрээнд байгал орчин учирч буй сөрөг нөлөөллийг бууруулах, иргэдийн санхүүгийн мэдлэгийн дээшлүүлэх чиглэлээр 2023 онд дараах ажлуудыг санаачлан хэрэгжүүлээ.



Ажил 1. Цөлжилтийн эсрэг моджуулалтын аян

2022 он Монгол орны цөлжилтийн үнэлгээгээр Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 76.9 хувь нь цөлжилт, газрын доройтолд өртсөн нь тогтоогдсон бөгөөд үүний 56 хувь нь байгалийн үзэгдэлтэй холбоотой бол 44 хувь нь хүний үйл ажиллагаатай холбоотой гэсэн тоон үзүүлэлт цөлжилтийн төлөв байдлыг үнэлэх судалгаагаанд тусгагджээ. Иймээс бид цөлжилт, хөрсний доройтолын эсрэг "Гүнд Инвестмент" холдинг группын нийт ажилчид нийгэм, байгаль орчинд ээлтэй бодлогын хүрээнд "Ногоон Ази сүлжээ ТББ" - тай хамтран Төв аймгийн, Баянхангай сумын цөлжилттэй нутаг дэвсгэрд мод тарих арга хэмжээг 3 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа.



Ажил 2. "Мэдлэг түгээе" сургалт, хөгжлийн хөтөлбөр

Иргэдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор "Өрхийн санхүүгээ удирдах нь" сургалтыг, ажиллах хүчийг тогтвортой ажиллах орчин нөөцийг бүрдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор дэмжих хүний нөөц, удирдах ажилтнуудад чиглэсэн "Мэдлэг түгээе" сургалтыг үнэ төлбөргүйгээр зохион байгууллаа.



Ажил 3. Цаасны хэрэглээг багасгах арга хэмжээ

Бизнес явагдахад маш олон төрлийн хог хаягдал гардгаас 40% нь цаасны хэрэглээ байдаг бөгөөд 1 тонн цаас үйлдвэрлэхийн тулд 15-60 жил ургасан 24 модыг тайрдаг байна. Иймээс бид цаасны хэрэглээг бууруулахын тулд дараах арга хэмжээ авч цаасны хэрэглээг бодитоор бууруулан ажиллаж байна.


MyLife.mn
Тавтай морил




1, MyLife.mn веб сайтаар дамжуулан цахим гэрээ байгуулж эхэлсэн бөгөөд хэрэглэгч 4 төрлийн даатгалын гэрээг цахимаар байгуулах боломжтой боллоо.

2, MyLife.mn веб сайтаар дамжуулан нөхөн төлбөрийн материал хүлээн авах процессыг дижиталжуулан цахимаар хүлээн авдаг боллоо.

3, "ТУС Солюшн" ХХК-ны T U S S D+ "Менежментийн цогц платформ"-г системээр дамжуулан дотоод үйл ажиллагаанд хэрэглэгддэг цаасаар хэвлэгддэг баримт бичгүүдийг халж цаасны хэрэглээг буурууллаа.





national life

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Lead by Gund

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд



ТУЗ-ийн Дарга
Ж.БАТ-ИРЭЭДҮЙ



ТУЗ-ийн гишүүн
Б.БАЯРЦЭНГЭЛ



ТУЗ-ийн гишүүн
Г.МОНГОЛХҮҮ



ТУЗ-ийн гишүүн
Р.ГАНЧИМЭГ



ТУЗ-ийн хараат бус
гишүүн
А.АНАР

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, тус тайлангийн талаар ТУЗ-ийн дүгнэлтийг баталж шийдвэрлэв. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг гурван удаа зарлан хуралдаж компанийн хувьцааг хуваах, сонирхлын зөрчилтэй этгээдтэй хийх 3 хэлцлийн гол нөхцөлийг тогтоож хэлцэл хийх зөвшөөрөл олгох, охин компани болох Гүнд лайф проперти ХХК-ийн хувьцааг шилжүүлэх, ТУЗ-ийн ердийн гишүүн Ж.Эрдэнэнямыг үүрэгт ажлаас чөлөөх, А.Анарыг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилох буюу 7 асуудлыг хэлэлцэн баталж шийдвэрлэв.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын журамд заасны дагуу 2023 онд улирал бүрийн ээлжит хурлаар 23 асуудлыг, 5 удаагийн ээлжит бус хурлаар асуудлыг 24 асуудлыг, эчнээ саналын хуудсаар 1 асуудлыг хэлэлцэж, нийт 10 удаа хуралдав.

№	Хурлын хэлбэр	Хуралдсан огноо	Хурлын ирц
1	Ээлжит хурал	2024 оны 01 сарын 12	2024 оны 01 сарын 12-ны хурлын ирц 80%, 2023 оны 01 сарын 31-ний хурлын ирц 100%
2	Ээлжит бус хурал	2023 оны 02 сарын 17	2023 оны 02 сарын 17-ний хурлын ирц 80% байх, 02 сарын 28-ны хуралд 100%
3	Ээлжит бус хурал	2023 оны 04 сарын 04	100%
4	Ээлжит хурал	2023 оны 04 сарын 26	2023 оны 04 сарын 26, 2023 оны 05 сарын 05-ны өдрийн хурлын ирц 100%
5	Ээлжит бус хурал	2023 оны 06 сарын 13	2023 оны 06 сарын 13-ны хурлын ирц 83.3, 2023 оны 06 сарын 22-ны өдрийн хурлын ирц 66.6%
6	Ээлжит бус хурал	2023 оны 07 сарын 06	2023 оны 07 сарын 06-ны хурлын ирц 80%, 2023 оны 07 сарын 20-ны өдрийн хурлын ирц 80% байх
7	Ээлжит хурал	2023 оны 08 сарын 17	80%
8	Ээлжит бус /эчнээгээр/	2023 оны 10 сарын 25	100%
9	Ээлжит хурал	2023 оны 11 сарын 18	80%
10	Ээлжит бус хурал	2024 оны 12 сарын 13	2024 оны 12 сарын 13, 12 дугаар сарын 28, 2024 оны 01 дүтээр сарын 05-ны өдрийн хурлын ирц 100%

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2023 онд 49 асуудал хэлэлцсэнээс 11 асуудлын хүрээнд хариуцсан ажилтны боловсруулсан дүгнэлт, саналыг ТУЗ - 06 В маягтын дагуу дүгнэж, хэлэлцсэн асуудлыг баталж 41 тогтоол, хэлэлцсэн асуудлыг буцаан 5 тогтоол гаргаж шийдвэрлэв. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь өмнөх онуудтай харьцуулахад хэлэлцэх асуудлын тоо болон буцаасан асуудлын тоо буурсан төлөвтэй байх боловч жил бүр дунджаар 20 гаруй тооны системийн хэвийн үйл ажиллагааг хангах стратегийн суурь болон төрөлжсөн тогтолцоог бүрдүүлэх бодлогын баримт бичиг болон журмын шийдлийг хэлэлцэж байх ба энэ нь 2023 онд хэлэлцсэн нийт асуудлын 42 хувийг эзэлж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцсэн шийдлийн тоо



Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь “Компанийн засаглалын кодекс” -ийн хэрэгжилт 2022 онд 63.9 хувьтай үнэлэгдсэнтэй холбогдуулан Компани 2023 оны зорилгод “Компанийн засаглалыг кодексийг хэрэгжилтийг хангах шийдгүүдийг төгөлдөржүүлэх” з орилт тавин ажилласан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны жилийн эцсийн үнэлгээгээр 87.3 хувь буюу өмнөх оноос 23.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

№	Шаардлага /бүлгээр/	Авбал зохих оноо	2023 үнэлгээний оноо
1	НЭГДҮГЭЭР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	12	10
2	ХОЁРДУГААР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ	10	7
3	ГУРАВДУГААР ЗАРЧИМ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ	6	4
4	ДӨРӨВДҮГЭЭР ЗАРЧИМ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО	6	6
5	ТАВДУГААР ЗАРЧИМ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА	8	8
6	ЗУРГААДУГААР ЗАРЧИМ. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ	6	6
7	ДОЛООДУГААР ЗАРЧИМ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ	8	8
8	НАЙМДУГААР ЗАРЧИМ. КОМПАНИЙН СОЁЛ	6	4
9	ЕСДҮГЭЭР ЗАРЧИМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ	10	10
	Нийт	72	63

Сонирхлын зөрчилтэй хэлцэлийн тайлан

Компани нь 2023 онд Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1 -д заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд хамаарах 6 хуулийн этгээд, 1 хувь хүнтэй Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлд заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөл, Хувьцаа эзэмшигчдийн хурлаас зөвшөөрөл авсны үндсэн дээр 236.2 сая төгрөгийн үнийн дүн бүхий хэлцлийг хийв.

№	Сонирхлын зөрчилтэй этгээдийн нэр	Сонирхлын зөрчилтэй хэлцлийн нэр	Хэлцлийн үргэлжлэх хугацаа	Хэлцлийн үнийн дүн
1	ТУС Солюшн ХХК	Tuss D+Дижитал платформ ашиглах гэрээ	2023.01.27-ны өдрөөс 2027.12.31	13,702,500
2		Google workspace бүтээгдэхүүнийг ашиглуулах гэрээ	2023.01.31 өдрөөс 2028.02.07	7,983,360
3	Гүнд Хэлткэр энд эдүкэшн сан ТББ	Хувь оролцоотой эрүүл мэндийн даатгалын гэрээ	2023-04-09 өдрөөс 2024-04-09	17,105,566
4	Синержи фонд солюшн ххк	Хугацаат амь насны даатгалын гэрээ	2023/8/1 өдрөөс 2028/8/1	185,091
5	Гүнд инвестмент ХХК	Менежментийн үйлчилгээний гэрээ	2023.01.01 өдрөөс 2023.12.31	108,000,000
6		Мэдлэг солилцох төвийн өрөөг ашиглах гэрээ	2023.02.08 өдрөөс 2023.12.31	7,600,000
7	Рийч Пойнт ХХК	"Үл хөдлөх эд хөрөнгийн үйлчилгээний гэрээ"	2023.01.01-ээс 2023.12.31 хүртэл 1 жилийн хугацаатай	1,520,000
8		Оффисын талбайн үйлчилгээний гэрээ	2023.01.01-ээс 2023.12.31 хүртэл 1 жилийн хугацаатай	18,240,000
9	Хүлэгүүд спорт менежмент" ХХК	Ивээн тэтгэгчээр хамтран ажиллах гэрээ болон даатгалын гэрээ	Энэхүү гэрээ нь гэрээг байгуулсан өдрөөс тоолон 1 жил	50,000,000
10	Д.Саранчимэг	Бараа худалдах, худалдан авах гэрээ	2023 оны 12 сарын 25-ны өдрийг дуустал	11,905,000
	нийт			236,241,517

Гүйцэтгэх захирлын үүрэг, цалин, урамшууллын шалгуурыг шинэчилэн тогтоолоо

Нэйшнл лайф даатгал ХХК-ийн толгой компани болох Гүнд Инвестмент ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 01-р сарын 08-ны өдрийн 22/02/06 тоот тогтоолын хавсралтаар “Гүйцэтгэх захирлыг сонгон шалгаруулах, ажиллуулах, ажлын үр дүнг үнэлэх журам”-ыг баталж, тус журмын дагуу гүйцэтгэх захирлын үүрэг, хариуцлага, цалин хөлсний бүтцийг шинэчлэн тогтоолоо.

1. Гүйцэтгэх захирлын үүргийн тогтолцоо

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 -д “компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах” үндсэн чиг үүргийн хүрээнд “Гүйцэтгэх захирал гэж компани, байгууллагын зорилгыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг бүхэлд нь манлайлах, дэмжих үүрэг хүлээсэн ажилтныг;” гэж агуулгыг өргөжүүлэн тодорхойлж дараах цогц үүргүүдийг хүлээхээр тусгагдсантай холбогдуулан 2023 онд Гүйцэтгэх захирлын хөдөлмөрийн гэрээнд өөрчлөлт оруулав. Үүнд:

- Гүйцэтгэх захирлын манлайлах үүрэг: оролцогч талуудын гүйцэтгэх үүргүүдийг компанийн зорилгыг тогтвортой хэрэгжүүлэхэд системийг үүсгэх, чиглүүлэх, төгөлдөржүүлэх үүргийг хүлээнэ;
- Гүйцэтгэх захирлын дэмжих үүрэг: Компанийн зорилгыг хэрэгжүүлэх үүргүүдийн гүйцэтгэлийг дэмжсэн, зорилгын хэрэгжилтийн үр дүнд эерэг нөлөөтэй, системийг чиглүүлэх, үүсгэх, төгөлдөржүүлэх ба уялдуулах үүргүүдээс бусад үүргүүдийг хүлээнэ;

2. Гүйцэтгэх захирлын цалин хөлсний бүтэц

Компанийн урт хугацааны тогтвортой өсөлтийг бий болгоход Байгаль орчин, нийгэмд (БОНд) үзүүлсэн нөлөөлөл, хөдөлмөрийн нөөцийн төлөвшилт, системийн үйл ажиллагааны үр дүн, зорилгыг хэрэгжилтэд тулгарч буй саад, бэрхшээлүүдийг даван туулах системийн шийдлүүдийн төлөвшилтийн түвшин ач холбогдлыг харгалзан үзэж Гүйцэтгэх захирлын цалин хөлсний бүтэц болон урамшууллын шалгуурыг шинэчилэн тогтоолоо.

№	Цалин хөлсний нэр	Цалин, урамшуулал олгох шалгуур
1	Гүйцэтгэх захирлын сарын цалин	1, Гүйцэтгэх захирлын ажилласан цаг 2, Гүйцэтгэх захирлын үүргийн гүйцэтгэл
2	Гүйцэтгэх захирлын богино хугацааны урамшуулал	1, Компанийн Системийн үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлт буюу СҮДҮ 2, Гүйцэтгэх захирлын Манлайллын индекс - Компани, байгууллагын эрүүл мэндийн төлөв байдлын ТУС индекс; - Хөдөлмөрийн нөөцийн төлөвшилтийн индекс; - Байгаль орчин, нийгэмд (БОНд) үзүүлсэн нөлөөллийн индекс;
3	Гүйцэтгэх захирлын урт хугацааны урамшуулал	1, Компанийн ажилтнуудын Хувийн гүйцэтгэлийн индекс 2, Гүйцэтгэх захирлын Манлайллын индекс - Компани, байгууллагын эрүүл мэндийн төлөв байдлын ТУС индекс; - Хөдөлмөрийн нөөцийн төлөвшилтийн индекс; - Байгаль орчин, нийгэмд (БОНд) үзүүлсэн нөлөөллийн индекс;

Дотоод аудит

Дотоод аудит нь компанийн үйл ажиллагааг сайжруулах, түүний үнэ цэнийг нэмэгдүүлэхэд зорилготой, баримт нотолгоонд үндэслэн хараат бус дүгнэлт гаргах, зөвлөх үйл ажиллагаа юм.

Дотоод аудитын тогтолцоо

Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны аудитын чиг үүргийг Нэйшнл лайф даатгал ХХК -ийн толгой компани болох Гүнд Инвестмент ХХК-аас дараах байдлаар хэрэгжүүлдэг. Үүнд:

1. Санхүүгийн үйл ажиллагааны дотоод аудитын хүрээнд

- 1.1. 7 хоног бүрийн мөнгөн гүйлгээний мэдээлэлд хяналт тавих;
- 1.2. Санхүүгийн үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дотоод дүрэм, журамд нийцсэн эсэхийг хянан баталгаажуулах;

2. Үйл ажиллагааны аудитын хүрээнд

- 2.1. Улирал бүр тайлант улиралд Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирлаас гаргасан шийдвэр нь хууль тогтоомж, дотоод дүрэм, журамд нийцсэн эсэхийг хянан баталгаажуулах;
- 2.2. Байгууллагын эрүүл мэндийн төлөв байдлын мониторинг, Системийн үйл ажиллагааны үр дүн /СҮДҮ/-гийн мониторинг, Байгаль орчин, нийгэмд /ТУС-БОНд / үзүүлсэн нөлөөллийн нэгдсэн индексийн мониторинг, АЧ нөөцийн мониторинг, дүрэм болон журмын хэрэгжилтэд мониторинг хийх;
- 2.3. Мониторинг хариуцсан ажилтны гаргасан Бодлогын баримт бичгийн хэв шинжийн бүрдэл, Системийн үйл ажиллагааны гүйцэтгэл /САГҮ/-ийн мониторинг, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл зэрэг мониторингийн дүгнэлтийг хянан баталгаажуулах;
- 2.4. Шинжийн бүрдэл, Системийн үйл ажиллагааны гүйцэтгэл /САГҮ /-ийн мониторинг, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл зэрэг төрлийн компанийн Мониторинг хариуцсан ажилтны дүгнэлтийг хянан баталгаажуулах;


Дотоод аудитын хүрээнд хийгдсэн ажлын мэдээлэл:

- Компанийн санхүүгийн үйл ажиллагааны хяналтын чиглэлээрх 7 хоногийн мөнгөн гүйлгээний тайлангаар зөрүү үүсээгүй, 2023 оны I I -р улиралд Толгой компаниас хийгдсэн “Санхүүгийн үйл ажиллагааны хяналт”-аар материаллаг бус шинжтэй асуудал илрүүлж, ирүүлсэн зөвлөмжийн дагуу залруулан ажиллалаа.
- Компанийн үйл ажиллагааны аудитын чиглэлээр 2023 онд Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирлаас гаргасан шийдвэр нь хууль тогтоомж, дотоод дүрэм, журамд нийцсэн гэж дүгнэлээ.
- Мониторингийн журамд заасан 12 төрлийн мониторингийн дүгнэлтээр илэрсэн асуудлыг Компанийн “Оношилгоо мониторинг зөвлөл”-өөр хэлэлцүүлэн асуудлын шалтгааныг тогтоох, шаардлагатай ажлыг төлөвлөн компанийн үйл ажиллагааг тасралтгүй сайжруулах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.

Санхүүгийн үзүүлэлт

Огноо	Даатгалын хураамжийн орлого	Нөхөн төлбөр	Нийт хөрөнгө	Нөөц сан	Цэвэр ашиг
2023	3.000.457	2.067.545	9.908.451	2.874.693	6.200.494
2022	2.565.360	1.368.777	10.079.231	2.408.159	6.959.005

Хураамжийн орлого өмнөх оныхоос 16.9 хувиар нэмэгдсэн. Харин нийт олгосон нөхөн төлбөр өмнөх оноос 51 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



Хураамжийн орлого өмнөх оныхоос 16.9 хувиар нэмэгдсэн. Харин нийт олгосон нөхөн төлбөр өмнөх оноос 51 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Төлбөрийн чадварын харьцаа

Компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төлбөрийн чадварын түвшин 2-р түвшинд (2022 онд 300.18%) байгаа нь Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журмын 2.19-д заасан “Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааг хангаж буй эсэхийг тодорхойлж, даатгагчийн төлбөрийн чадварын хоёрдугаар түвшин буюу даатгагчийн төлбөрийн чадвар хангалттай гэж үзнэ” гэж заасны дагуу төлбөрийн чадварын шаардлагыг хангаж байна.

Аудитлагдсан тайлан

Аудитын тайлангаас дүгнэлт, санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй байдлын тайлангийн хэсгийг оруулах

Хараат бус аудиторын дүгнэлт

"Грант Торнтон аудит" ХХК
Далай тауэр, ЮНЕСКО-н өмнө
гудамж, Сүхбаатар дүүрэг-1,
Улаанбаатар 14230,
Монгол улс
Т + 97670 110744
Ф + 97670 110722

Grant Thornton Audit LLC
Dalai Tower, UNESCO street,
Sukhbaatar District-1,
Ulaanbaatar 14230, Mongolia
T + 97670 110744
F + 97670 110722

"Нэйшнл лайф даатгал" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд:

Дүгнэлт

Бид "Нэйшнл лайф даатгал" ХХК (цаашид "компани" гэх)-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-нээрх дараах санхүүгийн тайлангуудад (цаашид "санхүүгийн тайлан" гэх)-д аудит хийлээ. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайлан,
- Уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан,
- Өмчийн өөрчлөлтийн тайлан,
- Мөнгөн гүйлгээний тайлан болон
- Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй,
- Бусад тайлбар тодруулгууд

Бидний дүгнэлтээр, "Нэйшнл лайф даатгал" ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан дүрэм, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа *Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага* гэсэн хэсэгт харуулав.

Хараат бус байдал

Бид Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус Компаниас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, зохистой гэж итгэж байна.

Санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2023 оны 12 сарын 31- ний яүлдэгдэл	2022 оны 12 сарын 31- ний яүлдэгдэл
Хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	7	226,131	1,471,670
Даатгалын авлага	8	67,364	131,673
Бусад санхүүгийн хөрөнгө	9	107,294	1,720,874
Бусад санхүүгийн бус хөрөнгө	10	242,393	253,681
Хөрөнгө оруулалт	11	7,454,396	6,435,129
Үндсэн хөрөнгө (цэвэр)	12	1,772,373	61,508
Биет бус хөрөнгө (цэвэр)	13	38,500	4,696
Нийт хөрөнгө		9,908,451	10,079,231
Өр төлбөр ба эздийн өмч			
Өр төлбөр			
Даатгалын өглөг	14	9,097	8,117
Бусад санхүүгийн бус өр төлбөр	15	675,979	237,415
Нөөц сан	16	3,022,881	2,874,694
Нийт өр төлбөр		3,707,957	3,120,226
Эздийн өмч			
Хувьцаат капитал	17	6,000,750	6,000,750
Хуримтлагдсан ашиг		199,744	958,255
Эздийн өмчийн дүн		6,200,494	6,959,005
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн		9,908,451	10,079,231

Орлогын дэлгэрэнгүй тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2023 он	2022 он
Даатгалын үйл ажиллагаа			
Даатгалын хураамжийн нийт орлого	18	3,000,457	2,565,360
Даатгалын хураамжийн буцаалт	19	(248,703)	(5,747)
Давхар даатгалын хураамжийн зардал	20	(31,863)	(28,112)
Даатгалын хураамжийн цэвэр орлого		2,719,891	2,531,501
Нийт төлсөн нэхэмжлэл	21	(2,067,545)	(1,368,777)
Даатгалын хураамжийн орлогын дүн		652,346	1,162,724
Хувь оролцоогүй гэрээний нөөц сангийн өөрчлөлт	22	(121,773)	(466,805)
Даатгалын нөөц сангийн өөрчлөлтийн дүн		(121,773)	(466,805)
Хөрөнгө оруулалтын орлого	23	1,053,974	825,585
Бусад орлого	24	-	36,000
Даатгалын хураамжийн бус орлогын дүн		1,053,974	861,585
Даатгалын орлогын дүн		1,584,547	1,557,504
Ерөнхий удирдлагын зардал	25	(1,500,001)	(1,403,816)
Борлуулалт маркетингийн зардал	26	(247,147)	(127,907)
Үйл ажиллагааны зардалын дүн		(1,747,148)	(1,531,723)
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг, алдагдал	27	64,235	(22,553)
Валютын ханшийн өөрчлөлтийн ашиг	28	(27,261)	167,871
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг, (алдагдал)-ын дүн		36,974	145,318
Татвар төлөхийн өмнөх ашиг		(125,627)	171,099
Орлогын татварын зардал	29	(90,734)	(126,116)
татварын дараах ашиг		(216,361)	44,983